



УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
САНДАГИЙН БЯМБАЦОГТ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Жуковын АЛДАРЖАВХЛАН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-23-46, Факс: 32-70-16
E-mail: aldarjavkhlan@parliament.mn
<http://www.parliament.mn>


2026. 04.29 № УИХ-03/4601
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Ж.АЛДАРЖАВХЛАН

0000000052



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Жуковын АЛДАРЖАВХЛАН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-23-46, Факс: 32-70-16
E-mail: aldarjavkhan@parliament.mn
http://www.parliament.mn

2025. 03. 19 № УИХ-03/3165

танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

“Монгол Улсын Их Хурлын тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, “Хууль тогтоомжийн тухай” хуулийн 5 дугаар зүйл, 8 дугаар зүйлийн 8.1.8-т заасны дагуу “Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль” /шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулахаар хуулийн төслийг санаачлан боловсруулж Монгол Улсын Засгийн Газрын хуралдаанаар хэлэлцүүлэн саналыг авч Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр баримт, бүрдүүлбэрийг хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хуулийн төсөл, үзэл баримтлал, Засгийн газрын санал болон холбогдох материалыг хавсаргав.

Хавсралт 8 хуудастай

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Ж.АЛДАРЖАВХЛАН

0000000060

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 8 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“9.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангийн санаачлан боловсруулсан Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл


ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангийн санаачлан боловсруулсан Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд дараах саналыг хууль санаачлагчид уламжлахаар тогтов:

1.Хуулийн төсөлд тусгасан асуудлыг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээ, мөн хуулийн 26.5, 26.6-д заасан хяналтын сонсголоос гарсан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, чиглэл өгсний дагуу холбогдох Байнгын хороо хууль тогтоомжийн төсөл боловсруулж, санал, дүгнэлтийн хамт нэгдсэн хуралдаанд танилцуулах зохицуулалтын хүрээнд шийдвэрлэх боломжтой байгааг анхаарах;

2.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасан Улсын Их Хурлын хяналтын сонсголын төрөлд үр дүнгийн сонсголын талаар зохицуулаагүй, түүнчлэн хуулийн төсөлд үр дүнгийн сонсголын зохион байгуулалт, процессын талаар тусгаагүй байна;

3.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.6 дахь хэсэгт “Улсын Их Хурлын хяналтын сонсголыг явуулснаас хойш нэг жилийн дотор тухайн асуудлаар дахин сонсгол явуулахгүй” гэж тодорхой заасныг анхаарах;

4.Хууль тогтоомжийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагыг тодорхойлсон судалгаа, үнэлгээ хийгээгүй байгаа нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт “Хууль санаачлагч хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсны, эсхүл хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр үзэл баримтлалын төсөл боловсруулна” гэж заасан шаардлагыг хангахгүй байна.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025. 02. 18 № хэрг / 483
танай _____-ны № _____-т

**Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай**

Таны санаачлан боловсруулж Засгийн газрын санал, дүгнэлт авахаар ирүүлсэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг хүргүүлж байна.

Хавсралт ...¹ хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Н.УЧРАЛ

000255002146

БАТЛАВ

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Ж.АЛДАРЖАВХЛАН

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ
/ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА-Д НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8-д заасны дагуу Улсын Их Хурал нь хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах онцгой бүрэн эрхтэй бөгөөд парламентын нээлттэй сонголт бол Улсын Их Хурал хяналт шалгалтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд өндөр ач холбогдолтой, олон нийтийн оролцоотой механизм болдог.

Энэхүү зорилго, ач холбогдлыг тусгаж Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах Засгийн газрын үйл ажиллагаа, хууль тогтоомжийн биелэлтийг Улсын Их Хурлаас хянан шалгахтай холбогдсон харилцааг бүхэлд нь эргэн харж 2024 оны 5 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан. Мөн уг хууль батлагдсантай холбоотойгоор Нийтийн сонголын тухай хуульд заасан ерөнхий хяналтын сонголыг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу явуулахаар хуульчилсан.

Дээр дурдсанаар парламентын сонголт зохион байгуулах нь өндөр ач холбогдолтой хэдий ч сонголын үр дүнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний биелэлт, үр дүнг тооцож, шалгах үр дүнгийн сонголын зохион байгуулах нь парламентын аливаа шийдвэр, шийдвэрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээний биелэлтийг тооцох, нээлттэй сонсох ач холбогдолтой юм.

Мөн Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгасан Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, төр-хувийн хэвшил-иргэний нийгмийн хамтын ажиллагаа бүх хүрээнд өргөжин, хүний эрхийг бүрэн хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болох зорилгын хүрээнд 2021-

2030 онд Улсын Их Хурлын хууль тогтоох, бодлого тодорхойлох, төлөөлөх, хяналт тавих чадавх сайжирч парламентын засаглал бэхэжсэн байхаар хүрэх үр дүнг тодорхойлсон.

Иймд Монгол Улсын Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд зохион байгуулсан хяналтын сонсголоос гарсан санал, дүгнэлт, чиглэлтэй холбоотойгоор үр дүнгийн сонсголыг зохион байгуулахтай холбоотой эрх зүйн үндсийг хуульчлах шаардлагатай байна.

Хоёр. Хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ.

Хуулийн төсөл нь Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд зохион байгуулсан хяналтын сонсголоос гарсан санал, дүгнэлт, чиглэлтэй холбоотойгоор үр дүнгийн сонсголыг зохион байгуулахтай холбоотой харилцаанд хамаарах бөгөөд үр дүнгийн сонсгол зохион байгуулах эрх зүйн үндсийг тодорхойлно.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль эрх зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал.

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар сонсголын үр дүнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний биелэлт, үр дүнг тооцох хууль эрх зүйн орчин бүрдэнэ гэж үзэж байна.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг сайжруулах зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон түүний үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулна.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ
/ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-Д НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Парламентын сонсгол зохион байгуулах нь өндөр ач холбогдолтой хэдий ч сонсголын үр дүнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний биелэлт, үр дүнг тооцож, шалгах үр дүнгийн сонсголын зохион байгуулах нь парламентын аливаа шийдвэр, шийдвэрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээний биелэлтийг тооцох, нээлттэй сонсох ач холбогдолтой юм.

Иймд Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд зохион байгуулсан хяналтын сонсголоос гарсан санал, дүгнэлт, чиглэлтэй холбоотойгоор үр дүнгийн сонсголыг зохион байгуулахтай холбоотой эрх зүйн үндсийг хуульчлах шаардлагыг харгалзан хуулийн төслийг боловсруулав.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд зохион байгуулсан хяналтын сонсголоос гарсан санал, дүгнэлт, чиглэлтэй холбоотойгоор үр дүнгийн сонсголыг зохион байгуулахтай холбоотой харилцаанд хамаарах бөгөөд үр дүнгийн сонсгол зохион байгуулах эрх зүйн үндсийг тодорхойлох бөгөөд уг хуулийн 6 дугаар бүлэг буюу Монгол Улсын Их Хурлын хяналтын сонсгол, түүний төрөл, зохион байгуулалттай холбоотой 26 дугаар зүйлд нэмэлт оруулахаар боловсруулав.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-Д НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Парламентын сонсгол зохион байгуулах нь өндөр ач холбогдолтой хэдий ч сонсголын үр дүнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний биелэлт, үр дүнг тооцож, шалгах үр дүнгийн сонсголын зохион байгуулах нь парламентын аливаа шийдвэр, шийдвэрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээний биелэлтийг тооцох, нээлттэй сонсох нь түүнтэй адил чухал ач холбогдолтой юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8-д заасны дагуу Улсын Их Хурал нь хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах онцгой бүрэн эрхтэй бөгөөд парламентын нээлттэй сонсгол бол Улсын Их Хурал хяналт шалгалтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд өндөр ач холбогдолтой, олон нийтийн оролцоотой механизм болдог.

Энэхүү зорилго, ач холбогдлыг тусгаж Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах Засгийн газрын үйл ажиллагаа, хууль тогтоомжийн биелэлтийг Улсын Их Хурлаас хянан шалгахтай холбогдсон харилцааг бүхэлд нь эргэн харж 2024 оны 5 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан. Мөн уг хууль батлагдсантай холбоотойгоор Нийтийн сонсголын тухай хуульд заасан ерөнхий хяналтын сонсголыг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу явуулахаар хуульчилсан.

Дээр дурдсанаар парламентын сонсгол зохион байгуулах нь өндөр ач холбогдолтой хэдий ч сонсголын үр дүнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний биелэлт, үр дүнг тооцож, шалгах үр дүнгийн сонсголын зохион байгуулах нь парламентын аливаа шийдвэр, шийдвэрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээний биелэлтийг тооцох, нээлттэй сонсох ач холбогдолтой юм.

Мөн Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгасан Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, төр-хувийн хэвшил-иргэний нийгмийн хамтын ажиллагаа бүх хүрээнд өргөжин, хүний эрхийг бүрэн хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болох зорилгын хүрээнд 2021-2030 онд Улсын Их Хурлын хууль тогтоох, бодлого тодорхойлох, төлөөлөх, хяналт тавих чадавх сайжирч парламентын засаглал бэхэжсэн байхаар хүрэх үр дүнг тодорхойлсон.

Иймд Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд зохион байгуулсан хяналтын сонсголоос гарсан санал, дүгнэлт, чиглэлтэй холбоотойгоор үр дүнгийн сонсголыг зохион байгуулахтай холбоотой эрх зүйн үндсийг хуульчлах шаардлагыг харгалзан Монгол Улсын Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу зохион байгуулсан хяналтын сонсголоос гарсан санал, дүгнэлт, чиглэлтэй холбоотойгоор үр дүнгийн сонсголыг зохион байгуулахтай холбоотой эрх зүйн үндсийг тодорхойлсон хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл нь үр дүнгийн сонсгол зохион байгуулах эрх зүйн үндсийг тодорхойлох бөгөөд уг хуулийн 6 дугаар бүлэг буюу Монгол Улсын Их Хурлын хяналтын сонсгол, түүний төрөл, зохион байгуулалттай холбоотой 26 дугаар зүйлд нэмэлт оруулахаар боловсруулав.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202.. оны ... дүгээр
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 26 дугаар зүйлд дараах агуулгатай 26.7 дахь хэсгийг нэмсүгэй.

“26.7.Энэ хуульд заасны дагуу зохион байгуулсан хяналтын сонсголоос гарсан санал, дүгнэлт, чиглэлтэй холбоотойгоор үр дүнгийн сонсголыг зохион байгуулж болно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ЗАРДЛЫН ТООЦООНЫ СУДАЛГАА**

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын дагуу хийсэн болно.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд зохион байгуулсан хяналтын сонсголоос гарсан санал, дүгнэлт, чиглэлтэй холбоотойгоор үр дүнгийн сонсголыг зохион байгуулахтай холбоотой харилцаанд хамаарах бөгөөд үр дүнгийн сонсгол зохион байгуулах эрх зүйн үндсийг тодорхойлох бөгөөд уг хуулийн 6 дугаар бүлэг буюу Монгол Улсын Их Хурлын хяналтын сонсгол, түүний төрөл, зохион байгуулалттай холбоотой 26 дугаар зүйлд нэмэлт оруулахаар боловсруулсан бөгөөд энэхүү хуулийн төслийг хэрэгжүүлэхэд улсын төсвөөс нэмэлт хөрөнгө шаардагдахгүй, харин үр дүнгийн сонсголыг зохион байгуулахад шаардлагатай зөвхөн зохион байгуулалтын зардлыг холбогдох байнгын хороод шийдвэрлэх боломжтой.

---o0o---